

Дундговь аймаг дахь
Төрийн аудитын газар



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“АЙМГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД
ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ, ТӨСВИЙН ЗАРЛАГЫГ
БУУРУУЛАХ, ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТИЙН ҮР
АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ САНАЛ ДҮГНЭЛТ

АУДИТЫН КОД: /ДУА-2024/03-10-НА-НА/

Дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох
Утас: 70592439

Аудитын менежер Т.Оюун-Эрдэнэ
Утас: 70592225

Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

Ахлах аудитор Ч.Бэрхсайхан

Аудитор О.Баярсайхан, Г.Үүрийнтуяа
Утас: 70593208

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим
хуудас: www.audit.mn

<u>Тайланг бэлтгэсэн:</u> Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар Дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох Аудитын менежер Т.Оюун-Эрдэнэ Ахлах аудитор Ч.Бэрхсайхан Аудитор О.Баярсайхан Шинжээч Г.Үүрийнтуяа Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70592208 дугаарын утас, 70592439 дугаарын факсаар харилцана уу. ХАЯГ: Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн	Аудитын тайланг баталгаажуулах тухай	4
	Товчилсон үгс	5
	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	6-8
	<u>БҮЛЭГ 1. Өмнөх онуудад болон тайлант оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр тасарч байгаа боловч 2025 оны төсөвт нэмэгдүүлэн төлөвлөсөн орлогуудад анхаарах. Зарим орлогыг төвлөрүүлэхтэй холбоотой хууль журмын хэрэгжилтийг хангуулах шаардлагатай байна</u>	9
	1.1 Дундговь аймгийн 2025 оны суурь орлогыг 32,827.2 сая төгрөгөөр тогтоож, УИХ-аас нийт орлогыг 33,053.2 сая төгрөгөөр баталсан бол аймгаас 9,505.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж 42,558.9 сая төгрөг байхаар санал гаргасан байна.	9-10
	1.2 Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн дагуу 1.4 тэрбум төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэх боломжтой байна.	10-12
	1.3 Түгээмэл тархацтай бүх төрлийн ашигт малтмалаас орох орлогыг хуульд заасан нөхцөл, журмын дагуу ашиглах нөхцөл бүрдээгүй байхад төлөвлөж байгаа нь төлөвлөгөөт орлого тасрах эрсдэлийг бий болгож байна.	12-13
	1.4 Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй ч үйл ажиллагаа явуулахгүй байгаа аж ахуй нэгжүүдийг гэрчилгээжүүлэх замаар газрын төлбөрийн орлогыг өмнөх оноос 2.5 дахин нэмэгдүүлэхээр төлөвлөсөн ч аж ахуй нэгжүүд гэрчилгээ авч төлбөр төлөх эсэх нь тодорхойгүй байна.	14
	1.5 Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг төлөх арга хэрэгслийг оновчтой сонгож, хог хаягдлын хураамжийн хэмжээг нормативт үндэслэн шинэчлэн тогтоосноор орлогын хэмжээг нэмэгдүүлэх боломжтой	14-16 18
	<u>Бүлэг 2 Төсвийн зардлыг үр ашигтай, хэмнэлтэй зарцуулах шаардлагатай байна.</u>	18-19
	2.1.Орон нутгийн төсвийн зардлыг төлөвлөхдөө арга хэмжээний хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг тодорхойлохгүй, төсвийн задаргаа байхгүй, тооцоо судалгаа хийгээгүй зэрэг нийтлэг алдаа дутагдал байгаа	

удирдлагын ордон, 213 тоот	нь зардлыг бодитой бус төлөвлөх эрсдэлийг бий болгож байна.	19-21
2024 оны 11 дүгээр сар	2.2.Орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээг хууль, журмын дагуу төлөвлөх шаардлагатай байна.	
	2.3.Зураг төсөв, эдийн засгийн тооцоо судалгаагүйгээр төлөвлөсөн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг хуульд заасны дагуу төсөвлөлтийн шаардлагыг хангуулах шаардлагатай байна.байна.	22
		23
	Дүгнэлт	24
	Зөвлөмж	
	Хавсралт	



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2024 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А/38

Мандалговь

Аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 20 дугаар зүйлийн 20.5, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторовын “Эрх шилжүүлэх тухай” 2023 оны А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх”-ийн 1.1, 1.4, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 18.9, 19 дүгээр зүйлийн 19.3 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Аймгийн 2025 оны төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргах” нийцлийн аудитын тайлан /ДУА-2024/03-10-НА-НА/-г нэгдүгээр, аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Нийцлийн аудитын тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулан, үр дүнгийн талаар 2025 оны 11 дүгээр сарын 1-ны дотор Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг Дундговь аймгийн Засаг дарга /С.Мөнхчулуун/-д зөвлөсүгэй.
4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон 2025 оны 4 дүгээр улиралд танилцуулахыг Аудитын хоёрдугаар нэгжийн ахлах аудитор /Ч.Бэрхсайхан/-д үүрэг болгосугай.



Р.МӨНХТОГТОХ

ТОВЧИЛСОН ҮГС

АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон улсын стандарт
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗДТГ	Засаг Даргын Тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
УИХ	Улсын Их Хурал
ЭЭС	Эм эргэлтийн сан

	АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторов 2022 оны А/67 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн төсөлд дүгнэлт гаргах аргачлал”-ын дагуу 2023 оны А/162 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын 2024 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө, Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг тус тус үндэслэн гүйцэтгэсэн.
Аудитын зорилго, зорилт:	Аймгийн Засаг даргаас аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар санал дүгнэлт гаргаж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдсэн. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: - Орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх санал гаргах - Орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд төсвийн зарлагыг бууруулах, үр ашгийг дээшлүүлэх санал гаргах
Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт:	Аудитад асуудлын шинжилгээний асуултын дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүйтэй холбоотой дараах хууль, эрх зүйн актын холбогдох заалтыг шалгуур үзүүлэлт болгон ашигласан. Үүнд: - Монгол Улсын Үндсэн хууль; - Төсвийн тогтвортой байдлын тухай хууль; - Төсвийн тухай хууль; - Төрийн аудитын тухай хууль; - Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль; - Төсвийн төсөл боловсруулах удирдамж - Татварын багц хуулиуд; - Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль; - Бусад холбогдох хууль, тогтоомж, журам, зааврууд.
Аудитын хамарсан хүрээ:	Аудитад аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтэс, аймгийн Татварын хэлтэс, бусад төсвийн байгууллагуудыг хамруулан, 2025 оны төсвийн төсөл, 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан, хүлээгдэж байгаа гүйцэтгэл, тайлант онд хийсэн төсвийн тодотгол, зохицуулалт хийсэн материал, судалгаа болон татварын орлогын бүрдүүлэлттэй холбоотой бусад холбогдох баримт материалд тулгуурлан аудитыг гүйцэтгэлээ. Монгол Улсын ерөнхийлөгч 2025 оны улсын төсөвт бүхэлд нь хориг тавьж УИХ хоригийг хүлээж авах шийдвэрийг гаргасан бөгөөд

"Орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх санал дүгнэлт гаргах"

<i>Аудитын арга зүй:</i>	“Төсвийн тухай хууль”-ийн 8 дугаар зүйлийн 8.5.1 дэх хэсэгт заасны дагуу аймгийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр ирүүлсэн аймгийн 2025 оны төсвийн төсөлд дүгнэлт гарган ажилласан болно. Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам (2020 он), Монгол Улсын Ерөнхий аудиторов 2022 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн А/67 тоот тушаалаар баталсан “Төсвийн төсөлд дүгнэлт гаргах аргачлал”, Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал (2020 он)-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулсан.
<i>Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа</i>	Аудитыг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга Р.Мөнхтогтох хянан удирдаж, аудитын менежер Т.Оюун-Эрдэнэ аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, аудитын 1, 2, 3 дугаар нэгж хуваарилагдсан ажлыг гүйцэтгэн, аудитын 2 дугаар нэгж саналуудыг нэгтгэн дүгнэлт гарган тэргүүлэх аудиторов баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2024 оны 11 сарын 21-ны өдрөөс 11 сарын 25-ны хооронд хийж гүйцэтгэлээ.
<i>Үндсэн мэдээлэл</i>	Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар нь Төрийн аудитын тухай хуулийн 6.3.2¹-т заасан бүрэн эрхийн хүрээнд жил бүр орон нутгийн төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар санал дүгнэлт гаргаж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлдэг. Сүүлийн жилүүдийн төсвийн төсөлд:

¹ Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн болон өргөн мэдүүлэх Монгол Улсын жилийн төсвийн төсөл, түүнчлэн аймаг, нийслэлийн Засаг даргаас тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн болон өргөн мэдүүлэх жилийн төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж, Улсын Их Хурал, Засгийн газар болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэх;

"Орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх санал дүгнэлт гаргах"

	2022 оны төсвийн төсөлд орлогын 2 төрөлд 115.0 сая төгрөгийг нэмэгдүүлэх, 5 төрөлд орлого нэмэгдүүлэх, бүрдүүлэх боломжийг судалж үзэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, зардал бууруулах төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх 6 санал хүргүүлсэн. Үүнээс 356.0 сая төгрөгийн орлогыг нэмэгдүүлэн, зөрчилтэй 1,570.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төсвийн төслөөс хасуулсан. 2023 оны төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх 1,510.7 сая төгрөг, бүрэн төвлөрүүлэх орлого 350.0 сая төгрөг, зардал хэмнэх 240.1 сая төгрөг, зардлын эх үүсвэр бий болгох 67.9 сая төгрөгийн санал хүргүүлсэн. Мөн аудитын тайлангаар сумдын Засаг дарга нарт 2, аймгийн Засаг даргад 8 заалт бүхий зөвлөмж хүргүүлсэн. Төрийн аудитын газрын зөвлөмжийн дагуу зөрчилтэй 940.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсвийн төслөөс хасуулж, зөрчлийг арилгасан. Малын тоо толгойн албан татварыг бэлчээрийн даацтай уялдуулан тогтоож, орлогыг төлөвлөн, сумдын ИТХ-ын тогтоолоор батлан, сумдын ОНХС-ийн эх үүсвэрийг 1,547.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэв. Дулааны эрчим хүч үйлдвэрлэгч байгууллагатай халаалтын гэрээг шинэчлэн хийснээр сард 34.3 сая төгрөг, жилдээ 240.1 сая төгрөгийн түлш халаалтын зардлыг хэмнэх боломжтой бөгөөд тооцооллыг зөвлөмжийн хамт аймгийн Засаг даргад хүргүүллээ. Төсвийн төсөлд өгсөн саналын хүрээнд нийт 1,547.4 сая төгрөгийн үр өгөөжийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлэв. 2024 оны төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх 174.7 сая төгрөг, орлого төвлөрүүлэх боломжит 1,434.0 сая төгрөг, зардал хэмнэх 195.0 сая төгрөг, зардлын эх үүсвэр бий болгох 67.1 сая төгрөгийн санал болон Аймгийн Засаг даргад 6, Сумын засаг дарга нарт 2 зөвлөмжийг тус тус хүргүүлсэн.



БҮЛЭГ 1. Өмнөх онуудад болон тайлант оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр тасарч байгаа боловч 2025 оны төсөвт нэмэгдүүлэн төлөвлөсөн орлогуудад анхаарах. Зарим орлогыг төвлөрүүлэхтэй холбоотой хууль журмын хэрэгжилтийг хангуулах шаардлагатай байна

1.1. Дундговь аймгийн 2025 оны сүүрх орлогыг 32,827.2 сая төгрөгөөр тогтоож, УИХ-аас нийт орлогыг 33,053.2 сая төгрөгөөр баталсан бол аймгаас 9,505.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж 42,558.9 сая төгрөг байхаар санал гаргасан байна.

Дундговь аймгийн 2025 оны төсвийн төсөлд төсвийг санхүүжүүлэх эх үүсвэрийг 94,627.5 сая төгрөгөөр баталсан нь өмнөх оноос 26,076.7 сая төгрөгөөр буюу 34.1 хувиар өссөн байна. Төсвийг санхүүжүүлэх эх үүсвэрийн 24,007.4 сая төгрөг буюу 25.4 хувь нь улсын төсвөөс аймгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг, 21,544.6 сая төгрөг буюу 22.8 нь аймгийн татварын болон татварын бус орлогоос, 21,817.0 сая төгрөг буюу 23.0 хувь нь орон нутгийн ерөнхий орлогын үлдэгдлээс, 18,250.4 сая төгрөг буюу 19.3 нь улсын төсвөөс аймгийн төсөвт авах орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгээс, 9,008.2 сая төгрөг буюу 9.5 хувийг бусад эх үүсвэрээс бүрдүүлэхээр тус тус төлөвлөсөн байна.

Аймгийн 2025 оны төсвийн орлогыг 42,558.9 сая төгрөг байхаар төлөвлөж өмнөх оноос 14,771.3 сая төгрөг буюу 53.2 хувиар нэмэгдүүлсэн байна. Тус орлогын 21,007.0 сая төгрөг буюу 49.4 хувийг сумдын төвлөрсөн, үлдсэн 21,551.9 сая буюу 50.6 хувийг аймгийн төвлөрсөн төсвийн орлогоор бүрдүүлэхээр тус тус төлөвлөжээ.

2025 оны төсвийн орлогыг УИХ-аас 33,053.2 сая төгрөгөөр УИХ-аас баталсныг аймгаас 6 нэр төрлийн 9,505.7 сая төгрөгийн орлогыг нэмэгдүүлж, нийт төсвийн орлогыг 42,558.9 сая төгрөг байхаар санал гаргасан байна. Үүнд:


- Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 1,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 12,500.0 сая төгрөг
- Газрын төлбөрийг 3,144.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 5,000.0 сая төгрөг
- Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийг 11,7 сая төгрөгөөр нэмэгдүүлж 836.7 сая төгрөг
- Хүү торгууль-ТХШ-ийг 5,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 5,000.0 сая төгрөг
- Татварын бус хүүгийн торгууль 150.0 төгрөгөөр нэмэгдүүлж 450.0 сая төгрөг
- Дуудлага худалдаа, сонгон шалгаруулалтын орлого 200.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 300.0 сая төгрөг байхаар тус тус төлөвлөсөн байна.

Аймгийн 2025 оны төсвийн төслийн орлогын төлөвлөгөөнд цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 12,500.0 сая төгрөгөөр төсөвлөгдсөн бөгөөд 2024 оны төлөвлөгөөнөөс 2,921.0 сая төгрөг буюу 30.5 хувиар нэмэгдүүлсэн байна. Энэ нь Төрийн албан хаагчдын цалин, хөлсийг 2025 онд инфляцын түвшинтэй уялдуулан 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 хувь нэмэгдүүлэх, улсын төсвийн байгууллагын албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл олгохтой холбоотой байна.

ААНОАТ хувьд 14,600.0 сая төгрөгөөр төсвийн төсөлд тусгагдсан байгаа нь өмнөх жилээс 3,823.2 сая төгрөг буюу 35.5 хувиар нэмэгдүүлсэн байна.

Аймгийн төсвөөс АХБ-ны МОН 2301 төсөл /Гурвансайхан сумын дэд бүтэц/ зээл, АХБ-ны МОН 3713 төсөл /Сайнцагаан, Эрдэнэдалай сумын цэвэрлэх байгууламж/ зээлийн нийт 1,630.9 сая төгрөгийг 2025 онд төлөхөөр төсвийн зардалд тусгасан боловч эх үүсвэр дээр дамжуулан зээлдүүлэхийн хүүгийн орлого 566.9 сая төгрөгийн бодит бус орлогыг төлөвлөсөн байна. Иймд дээрх 1,630.9 сая төгрөгийн зээлийн төлбөрийг төлөх эх үүсвэрийг аймгийн 2025 оны төсөвт бодитоор төлөвлөх шаардлагатай байна.

График1: Төсвийг санхүүжүүлэх эх үүсвэр 2023-2025(сая төгрөгөөр)



1.2.Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн дагуу 1.4 тэрбум төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэх боломжтой байна.

Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1², 6 дугаар зүйлийн 6.1³ тус тус заасны дагуу сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нэг малын тоо толгойд тухайн татварын жилд ногдуулах албан татварын хэмжээг тогтоосон байна.

Харин тус хуулийн 6.2⁴ -т заасан албан татварын хэмжээг бэлчээрийн даацыг харгалзан малын төрөл тус бүрээр тогтооно гэж заасан боловч сумд малын тоо толгойн албан татварын хэмжээг бэлчээрийн даацтай уялдуулан тогтоогоогүй байна.

Аймгийн хэмжээнд 2023 оны байдлаар бэлчээрийн даац хэтрээгүй сум байхгүй бөгөөд бэлчээрийн даацын багтаамж хонин толгойд шилжүүлснээр 2,984,255 байхад малын тоо 7,797,352 хонин толгой буюу бэлчээр ашиглалтын хувь 267.5%, бэлчээрийн даац 2.7 дахин хэтэрч, 2021 оноос 1 дахин өссөн үзүүлэлттэй байна. /График 2/


² Албан татвар төлөгчийн өмчилж буй Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа малын тоо толгойд албан татвар ногдуулна

³ Нэг малын тоо толгойд тухайн татварын жилд ногдуулах албан татварын хэмжээ нь 0-2000 төгрөг байна

⁴ Албан татварын хэмжээг бэлчээрийн даацыг харгалзан энэ хуулийн 6.1-д заасан хязгаарт багтаан сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, хотын Зөвлөл малын төрөл тус бүрээр тогтооно

"Орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх санал дүгнэлт гаргах"

График 2: 2021 он болон 2023 оны бэлчээрийн даац хэтрэлт /дахин/



Сайнцагаан, Эрдэнэдалай, Хулд, Дэрэн, Адаацаг, Луус, сумд 2021 оноос бэлчээрийн даац 1-2 дахин хэтэрч өссөн бол Дэлгэрхангай, Өлзийт, Цагаандэлгэр сумд хамгийн бага буюу 0.4-0.5 дахин хэтэрч өссөн байна.

Малын тоо толгойн албан татварын тогтоосон хэмжээг харахад бэлчээрийн даац 2.9 дахин их байгаа Говь-Угтаал сум адуу, үхэр, тэмээнд 2000, хонь 400, ямаа 500 төгрөг, бэлчээрийн даац 2.5 дахин их Өндөршил сум тэмээ 0, бусад малд бүгд 500 төгрөгөөр бэлчээрийн даацтай уялдуулаагүй тогтоосон байна. Харин бэлчээрийн даац бэлчээрийн даац хамгийн их 4.1 дахин хэтэрсэн Сайнцагаан сум 2024 онд өвөлжилт хүндэрч, цас их орсонтой холбоотой 2020 оны тогтоолоор батлагдсан татварын хэмжээг таван хувь бууруулан адуунд 750, хонь 200, ямаа 250, тэмээ, үхэрт 0 төгрөг ногдуулж, өмнөх татварын хэмжээ тогтоосон тогтоолоо хүчингүй болгосон байна.

Дээрх байдлаас дүгнэхэд малын тоо толгой өсөж, бэлчээрийн даац жилээс жилд нэмэгдэж байгаа боловч малын тоо толгойн албан татварыг бэлчээрийн даацтай уялдуулан тогтоох бодлого барьж ажиллаагүй байна.

Малын тоо толгойн албан татварын орлогын хувьд аймгийн дүнгээр 2023 онд 1,563.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөн гүйцэтгэлээр 1,157.0 сая төгрөгийн орлого төвлөрч биелэлт 74.0 хувьтай байсан бол 2024 онд 1,255.1 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөн хүлээгдэж буй гүйцэтгэл 770.9 сая төгрөг буюу 61.4 хувийн биелэлттэй байхаар байна. Энэ нь аймгийн хэмжээнд 2024 оны өвөл цас их орж, өвөлжилт хүндэрсэн холбоотой Адаацаг, Дэлгэрхангай, Дэрэн, Хулд сумд тухайн татварыг 0 болгон чөлөөлж, Өлзийт, Өндөршил, Сайнцагаан, Эрдэнэдалай сумд татварыг тавин хувь болгон хөнгөлсөнтэй холбоотой байна. Бусад сумдын хувьд малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1⁵-д зааснаар татварыг 2 тэнцүү хуваан төлөх бөгөөд 12 дугаар сард татвар төлөлт өндөр байх магадлалтай байна.

⁵ Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу ногдуулсан албан татварыг тэнцүү хоёр хуваан тухайн жилийн 7 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор өөрийн өмчилж байгаа малын тоо толгой тоологдож бүртгэгдсэн сум, дүүргийн төсөвт төлнө.

"Орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх санал дүгнэлт гаргах"

Малын тоо толгойн албан татварыг 2023 оны жилийн эцсийн мал тооллогын дүн, 2024 оны 09 сарын байдлаарх малын хорогдлын мэдээг үндэслэн сум тус бүрээр тооцоолоход аймгийн дүнгээр 1,465.3 сая төгрөгийн орлого төвлөрөх боломжтой байна. Иймд сумдын ОНХС-ийн орлогын эх үүсвэр дээрх хэмжээгээр нэмэгдэхээр байна.

Хүснэгт:1: Малын тоо толгойн татварын орлогын биелэлт/сая төгрөг/

Сум	2023			2024				2025 оны тооцоолсон орлого /2023 оны малын тоонд үндэслэн/
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт	Жилийн төлөвлөгөө	Гүйцэтгэл /10 сар өссөн/	ХБГ	Биелэлт ХБГ	
Адаацаг	60.0	62.5	104.1%	90.0	29.8	74.8	83.1%	95.6
Баянжаргалан	56.7	39.2	69.1%	65.0	18.8	42.8	65.8%	66.0
Говь-Угтаал	80.0	79.2	98.9%	80.0	21.6	38.6	48.3%	93.5
Гурвансайхан	122.0	94.1	77.1%	122.7	38.5	86.2	70.2%	121.7
Дэлгэрхангай	100.9	41.3	40.9%	65.0	18.0	34.0	52.3%	90.2
Дэлгэрцогт	69.6	65.1	93.5%	70.0	50.9	65.9	94.2%	77.8
Дэрэн	120.6	96.7	80.2%	55.1	26.9	30.5	55.4%	113.0
Луус	50.0	69.3	138.6%	70.0	23.7	43.7	62.5%	83.7
Өлзийт	156.6	119.5	76.3%	65.9	12.9	12.9	19.5%	140.2
Өндөршил	75.0	49.4	65.8%	37.5	45.8	45.8	122.2%	68.4
Сайнцагаан	166.0	117.7	70.9%	100.0	37.3	62.3	62.3%	85.8
Сайхан-Овоо	56.8	28.5	50.1%	80.5	16.4	28.2	35.1%	53.7
Хулд	50.0	56.7	113.3%	10.0	24.2	24.2	242.0%	78.8
Цагаандэлгэр	67.5	52.6	77.9%	66.5	11.4	34.9	52.5%	56.6
Эрдэнэдалай	332.0	185.5	55.9%	277.0	86.1	146.1	52.7%	240.2
Дүн	1,563.6	1,157.0	74.0%	1,255.1	462.4	770.9	61.4%	1,465.3

1.3.Түгээмэл тархацтай бүх төрлийн ашигт малтмалаас орох орлогыг хуульд заасан нөхцөл, журмын дагуу ашиглах нөхцөл бүрдээгүй байхад төлөвлөж байгаа нь төлөвлөгөөт орлого тасрах эрсдэлийг бий болгож байна.

Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон уурхайн талбайг 2018 онд аймгийн ИТХ-аас сум бүрээс судалгаа авч тусган баталсан. Ерөнхий төлөвлөгөө батлагдсанаас хойших хугацаанд сумдад түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, уурхайн зориулалтаар ашиглах талбайг жил бүрийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлээгүй байна.

2023 оны байдлаар аймгийн хэмжээнд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын 55, ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 1 аж ахуй нэгж, байгууллага байсан бол 2024 онд тусгай зөвшөөрлийн төлбөр төлөөгүй, эзэмших хугацаа дууссан 29 аж, ахуй нэгж байгууллагын тусгай зөвшөөрөл цуцлагдсан байна. Одоогоор хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 26, Баянжаргалан суманд ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 1 аж ахуй нэгж,

байгууллага байна. Эдгээр аж ахуй нэгж, байгууллагууд тогтмол үйл ажиллагаа явуулаагүй байна.

Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онуудтай харьцуулахад 2021-2022 онуудын төлөвлөгөө 48.3-62.5 хувиар тасарсаар байхад 2023-2024 онуудад орлогын төлөвлөгөөг 5-6 дахин нэмэгдүүлэн баталсан байна. Энэ нь төлөвлөгөө батлахдаа өмнөх оны гүйцэтгэлтэй уялдуулаагүй, бодитой тооцоо судалгаанд үндэслээгүйг харуулж байна.



2023 онд 15 сумдад 108.5 сая төгрөгийн орлогын төлөвлөгөө баталснаас 8 сумаас нийт 16.5 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна. Харин 2024 онд 120.0 сая төгрөгийн орлого төвлөснөөс 10 сарын байдлаар гүйцэтгэл 9.3 сая төгрөг ба хүлээгдэж буй гүйцэтгэл 26.8 сая төгрөг байгаа нь тайлант оны эцэст орлогын төлөвлөгөө тасрах төлөвтэй байна. Дээрх орлогын эх үүсвэрийг судлахад орлогын төлөвлөгөө биелүүлэх зорилгоор байгалийн нөөц ашигласан этгээдтэй гэрээ байгуулсан, ААНБ-аас нийгмийн хариуцлагын хүрээнд орсон гэх мэт орлого дийлэнх хувийг эзэлсэн байна. Өөрөөр хэлбэл хуульд заасан түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолтоос орох орлого огт төвлөрүүлээгүй байна. Энэ нь аймгийн хэмжээнд байгалийн баялаг ашигласан ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж, ахуйн нэгж байгууллага байхгүйтэй холбоотой бөгөөд орлогын төлөвлөгөө тасрах үндсэн шалтгаан болж байна.

Мөн түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, уурхайн зориулалтаар ашиглах талбайг жилийн төлөвлөгөөнд тусгаагүй, ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгж, байгууллагыг бий болгох талаар ажил төлөвлөөгүй нь 2025 оны төсвийн орлогын төлөвлөгөөнд түгээмэл тархацтай ашигт малтмалаас орох орлогыг 10.0 сая төгрөг байхаар төлөвлөсөн нь үндэслэлгүй байна гэж дүгнэхээр байна.

Иймд холбогдох албан тушаалтнууд Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1⁶, тус хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1⁷-д заасны дагуу шаардлагатай сумдад хуулийн шаардлага хангасан аж, ахуйн нэгж байгууллагад ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох, зөвшөөрөл бүхий аж ахуй нэгжийн үйл ажиллагааг тогтмолжуулах ажлыг зохион байгуулах шаардлагатай байгааг харуулж байна.

⁶ Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа, Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээдэд олгоно


⁷ аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон уурхайн талбайг тусгах

"Орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх санал дүгнэлт гаргах"

1.4. Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй ч үйл ажиллагаа явуулахгүй байгаа аж ахуй нэгжүүдийг гэрчилгээжүүлэх замаар газрын төлбөрийн орлогыг өмнөх оноос 2.5 дахин нэмэгдүүлэхээр төлөвлөсөн ч аж ахуй нэгжүүд гэрчилгээ авч төлбөр төлөх эсэх нь тодорхойгүй байна.

Газрын төлбөрийн орлогыг 2023 онд 556.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр 1,303.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлж биелэлт 234.1 хувь буюу төлөвлөгөө давж биелсэн. 2024 онд 2,000.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөж эхний 10 сарын байдлаар 1,217.7 сая орлогыг төвлөрүүлж гүйцэтгэл 60.9 хувийн биелэлттэй бөгөөд хүлээгдэж буй гүйцэтгэлээр 1,919.7 сая төгрөгийн орлого төвлөрч төлөвлөгөөний гүйцэтгэл 96.0 хувь буюу 80.3 сая төгрөгөөр тасрахаар байна.

Хүснэгт-1. Газрын төлбөрийн төлөвлөлт, гүйцэтгэлийг харуулбал:




Газрын төлбөрийн орлогыг 2025 оны төсвийн төсөлд өмнөх оноос 2.5 дахин нэмэгдүүлж 5,000.0 сая төгрөгөөр төлөвлөсөн байна. Аймгийн нутаг дэвсгэрт ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй ч олборлолтын үйл ажиллагаа явуулахгүй байгаа уул уурхайн 61 аж ахуй нэгжийн 71 нэгж талбайн 107.1 мянган га талбайг гэрчилгээжүүлэн 3,426.7

сая төгрөгөөр газрын төлбөрийн орлогыг нэмэгдүүлэхээр тооцоолж төлөвлөсөн хэдий ч аж ахуй нэгжүүд гэрчилгээ авч газрын төлбөр төлөх эсэх нь тодорхойгүй байна. Тиймээс газрын төлбөрийн орлого тасрах эрсдэлтэй байна.

1.5. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг төлөх арга хэрэгслийг оновчтой сонгож, хог хаягдлын хураамжийн хэмжээг нормативт үндэслэн шинэчлэн тогтоосноор орлогын хэмжээг нэмэгдүүлэх боломжтой

Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогын төлөвлөгөөг 2025 оны төсвийн төсөлд 195.0 сая төгрөг байхаар тусгасан нь өмнөх оноос 0.1 сая төгрөгөөр бууруулсан байна.

Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төлөвлөгөөний биелэлт 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 187.7 сая буюу 96.2 хувийн гүйцэтгэлтэй байхаар байна. Биелэлтийг сумдаар харьцуулж үзэхэд 7 сум 100.2-276.6 хувиар давуулан биелүүлж, үлдсэн 8 сумын орлогын төлөвлөгөө 24.8-56.5 хувиар тасарч байна. Орлогын гүйцэтгэл Гурвансайхан сум 184.5 хувь буюу 8.5 сая төгрөг, Сайнцагаан сум 104.4 хувь буюу 4.9 сая төгрөгөөр тус тус төлөвлөгөөгөө давуулан биелүүлсэн нь орлогын төлөвлөгөөний биелэлт нийт дүнгээр өсөхөд нөлөөлж байна.



Хог хаягдлын хураамжийн ногдуулалт хийх албан хаагч тодорхойгүй, татварын нэгдсэн системд хураамж төлөх айл өрх, албан байгууллагын мэдээллийг оруулдаггүй, хураамжийг цахилгааны төлбөртэй хамт авч байх ажлыг сумд хэрэгжүүлж эхлээгүй зэргээс шалтгаалан орлого төвлөрүүлэлт хангалтгүй байна.

Хог хаягдлын тухай хуулийн 41.7⁸-д заасныг үндэслэн “Дундговь аймгийн хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөр”-ийг 2018-2023 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөнд айл өрхийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг цахилгааны төлбөртэй хамтатган авч байхаар арга хэмжээг төлөвлөсөн. Энэхүү арга хэмжээг Говь-Угтаал сум, Сайнцагаан сум БЗӨБЦТС ТӨХК-ний Дундговь салбартай гэрээ байгуулан хэрэгжүүлж байгаа бөгөөд хог хаягдлын хураамжийн орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн байна. Гурвансайхан сумын багийн дарга нар хог хаягдлын хураамжийн төлөлтөд хяналт сайн тавьж ажилласнаар орлогыг 184.5 хувиар давуулан биелүүлсэн байна. Уг жишгээр бусад сумд хог хаягдлын үйлчилгээний хураамжийг цахилгааны төлбөртэй хамтатган авах, төлөлтийн байдалд холбогдох албан тушаалтан идэвх санаачилгатай ажилласнаар тус орлогын хэмжээ нэмэгдэх боломжтой.

⁸ Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг эрчим хүч, хэрэглээний цэвэр, бохир ус, дулаан, орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний төлбөртэй хамтатган хураах замаар төвлөрүүлж болно.

"Орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх санал дүгнэлт гаргах"

График 3: 2024 оны сумдын хог хаягдлын хураамжийн орлогын гүйцэтгэл(сая төгрөгөөр)




Дундговь аймаг дахь Төрийн аудитын газраас 2023 онд гүйцэтгэсэн “Хог хаягдлын менежментийг сайжруулах үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар сумд хог хаягдлын хураамжийн хэмжээг тогтоосон ч Хог хаягдлын тухай хуулийн 9.2.1 дэх заалт, Сангийн сайд болон БОАЖС-ын 2018 оны 192, А/243 дугаартай “Аргачлал батлах тухай” хамтарсан тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, булшлах зардлын нэгж тарифыг тооцох аргачлалын үндэслэн бодитой тогтоогоогүй гэсэн дүгнэлт гарсан. Тухайлбал тус аудитаар Сайнцагаан сумын гэр хорооллын 1 айл өрхийн хог хаягдлыг 1 сард зайлуулах зардал 22,968.0 төгрөг байхад хураамжийн хэмжээ 3,000 төгрөг буюу 7 дахин багаар тогтоогдсон судалгааны үр дүн гарсан. Ингэхдээ тооцоо судалгаа, нормативд үндэслээгүйгээс үүдэн үйлчилгээний хураамжийн гүйцэтгэл тасрах байдал өндөр болж байгаа юм. Иймд сумд хог хаягдлын хураамжийн хэмжээг тогтоохдоо дээрх аргачлалын дагуу энгийн хог хаягдлыг цуглуулж тээвэрлэх зардлын тарифыг тооцож, түүнд үндэслэн хог хаягдлын хураамжийн хэмжээг тогтоон, мөрдүүлэн ажиллах шаардлагатай байна.



БҮЛЭГ 2. Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ нь тооцоо судалгаанд үндэслээгүй, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин тодорхойгүй, үр дүнд суурилсан төсөвлөлтийн шаардлагыг хангаагүй байна

2.1. Орон нутгийн төсвийн зардлыг төлөвлөхдөө арга хэмжээний хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг тодорхойлохгүй, төсвийн задаргаа байхгүй, тооцоо судалгаа хийгээгүй зэрэг нийтлэг алдаа дутагдал байгаа нь зардлыг бодитой бүс төлөвлөх эрсдэлийг бий болгож байна.

Аймгийн 2025 оны орон нутгийн төсвийн зарлагыг 94,627.5 сая төгрөг байхаар төлөвлөсөн байна. Энэ нь 2024 оны төсвийн зарлагаас 24,076.7 сая төгрөг буюу 34.1 хувиар нэмэгджээ. Нийт зардлын 68,033.6 сая төгрөг буюу 71.9 хувийг



аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудад, 14,413.3 сая төгрөг буюу 15.2 хувийг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчаас сумын төсвийн ерөнхийлөн захирагчид олгох санхүүгийн дэмжлэг, 12,180.6 сая төгрөг буюу 12.9 хувийг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчаас сумын төсвийн ерөнхийлөн захирагчид олгох орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг эзэлж байна. Төсвийн зарлагыг бүтцээр нь авч үзвэл 51,566.7 сая төгрөг буюу 54.5 хувийг хөрөнгө оруулалтын зардал, 43,060.8 сая төгрөг буюу 45.5 хувийг урсгал зардал эзэлж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн барилгын үйлчилгээ, ашиглалтын зардал 106.3 хувь, ОНӨҮГ, улсын төсвийн байгууллагын албан хаагчдад олгох орон нутгийн нэмэгдлийн зардал 93.8 хувь, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардал 90.5 хувиар тус тус нэмэгдсэн нь хамгийн их өсөлттэй зардлууд байна.

Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээг хэрэгжүүлэхэд 2,130.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн нь өмнөх оноос 112.0 сая төгрөг нэмэгдсэн байна. Мөрийн хөтөлбөрт тусгагдсан ямар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх нь тодорхой бус, хэрэгжүүлэх арга хэмжээг төсвийн төсөлд долдугаар хавсралтаар баталсан боловч ирүүлээгүй байна.

Аймгийн 2025 оны төсөвт шинээр “Ид шидийн орон”-ны зардал 330.0 сая төгрөг, “Эрдмийн далай хүүхэд хөгжлийн төв”-ийн зардал 208.7 сая төгрөг, “Нийтийн тээврийн алдагдалд олгох татаас”-ын зардал 50.0 сая төгрөгийн зардлуудыг шинээр төсөвлөсөн бол өмнөх онд төсөвлөж байсан агаарын бохирдол бууруулах, дулааны алдагдалд олгох татаасын зардал 2025 оны төсөвт төлөвлөгдөөгүй байна.

Дээрх шинээр төлөвлөсөн зардлуудын төсвийн задаргаа байхгүй, тооцоо судалгаа хийгээгүй, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт байхгүй, тухайн байгууллагын өнгөрсөн оны үйл ажиллагааны тайлан, саналыг үндэслэн төлөвлөсөн нь бодитой бус, ямар төсөл арга хэмжээг санхүүжүүлэх нь тодорхойгүй байна.

Хот тохижуулах газар ОНӨААТҮГ-т олгох татаас 1,974.2 сая төгрөг олгохоор төлөвлөсөн нь 2024 оныхоос 617.8 сая буюу 45.5 хувиар нэмэгджээ. Санхүүжилтийг олгохдоо ямар чиг үүргийг гүйцэтгүүлэх нь тодорхой бус, алдагдлыг санхүүжүүлэх татаас хэлбэрээр олгож байгаа нь зөрчилтэй байна. Иймээс алдагдлыг санхүүжүүлэх биш төрийн чиг үүргийг гүйцэтгүүлэх гэрээ байгуулан тодорхой арга хэмжээг санхүүжүүлж, үр дүнг тооцож байх нь зүйтэй.

2.2.Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээг хууль, журмын дагуу төлөвлөх шаардлагатай байна.

Орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд нийт 31,322.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээс өмнөх онд хийгдсэн ажлыг үргэлжлүүлэхэд 5,303.2 сая төгрөгийн, шинээр барилга угсралт, их засварт 19,922.8 сая, тоног төхөөрөмжид 1,674.2 сая төгрөгийн, төсөл хөтөлбөр арга хэмжээнд 3,550.0 сая төгрөгийн, замын сангийн хөрөнгөөр 872.4 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөжээ.

Эдгээр ажлуудыг санхүүжүүлэх эх үүсвэрийн төлөвлөлтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт:№6

/сая төгрөг/

№	Үзүүлэлт	ОНХО	Их засвар	Замын сангийн хөрөнгөөр	дүн
1	Шилжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээ	5,303.2			5,303.2
2	Барилга угсралт, их засвар	14,178.9	5,743.9		19,922.8
3	Тоног төхөөрөмж	1,674.2			1,674.2
4	Төсөл, хөтөлбөр арга хэмжээ	3,550.0			3,550.0
5	Зам засвар, арчилгаа			872.4	872.4
6	НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	24,706.3	5,743.9	872.4	31,322.6
	2024 оны ОНХО-ын шилжих	5,303.2			5,303.2
1	2024 оны хэмнэлт	7,103.1	110.6	21.4	7,235.1
2	2025 оны ОНТ-өөс санхүүжих	12,300.0	5,633.3	851.0	18,784.3
3	НИЙТ ЭХ ҮҮСВЭР	24,706.3	5,743.9	872.4	31,322.6

Ирэх онд хийгдэх хөрөнгө оруулалтын хийгдэх төсөл хөтөлбөр арга хэмжээний төрөл болон санхүүжилтийн эх үүсвэрийг диаграмаар харьцуулан харуулбал:

График:№7



Диаграммаас харахад нийт хөрөнгө оруулалтын 18,784.3 сая төгрөг буюу 60 хувийг 2025 оны орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна. барилга угсралт, их засвар 24,617.8 сая төгрөг буюу нийт хөрөнгө оруулалтын 78.6 хувийг эзэлж байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх арга хэмжээг өмнөх онтой харьцуулбал:

Арга хэмжээ	2024 он	2025 он	Зөрүү /дахин/
Барилга угсралт, их засвар	3,659.2	24,617.8	6.7
Тоног төхөөрөмж	1,707.5	2,282.4	1.3
Төсөл, хөтөлбөр арга хэмжээ	1,226.0	3,550.0	2.9
Зам засвар, арчилгаа	670.4	872.4	1.3
Нийт дүн	7,263.1	31,322.6	4.3

Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтыг өмнөх онд 7,263.1 сая байсан бол 2025 онд 31,322.6 сая төгрөг болж 24,059.5 сая төгрөгөөр буюу 4.3 дахин нэмэгдсэн байна. Барилга угсралт, их засвар 6.7 дахин өссөн нь дийлэнх хувийг эзэлж байна.

Аймгийн урт хугацааны бодлогын баримт бичиг, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн 2025 оны жилийн хөгжлийн төлөвлөгөө батлагдаж гараагүй тул орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг дээрх бичиг баримт бичигтэй нийцсэн эсхийг тулгах боломжгүй байлаа. Хөрөнгө оруулалтын арга хэмжээг тус бүрийг зураг төсөв, шинээр баригдах барилгын ашиглалттай холбоотой судалгааг хянаж үзлээ. 2025 онд санхүүжигдэх зураг төсөвгүй 10,663.2 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээнээс 9,000.0 сая төгрөгийн 3 барилгын ашиглалтын тооцоо, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэрийн судалгаагүй, 197.1 сая төгрөгийн зураггүй 1 арга хэмжээ, 348.9 сая төгрөгийн зураг, төсөв баталгаажуулаагүй 1 арга хэмжээ буюу нийт 11,209.2 сая төгрөгийн зөрчилтэй арга хэмжээг төлөвлөсөн байна. Мөн төсөл арга хэмжээнүүдийг эрэмбэлж, нэн тэргүүний ач холбогдлоор нь төсөл арга хэмжээнүүдийг тодорхойлж жагсаалт гаргаагүй байна. Үүнд дараах зөрчилтэй арга хэмжээг төлөвлөсөн байна: Хүснэгтээр харуулбал:

"Орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх санал дүгнэлт гаргах"

№	Хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх-Дуусах	Төсөвт өртөг	2025 онд санхүүжигдэх	Тайлбар
1	Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайн гэрэлтүүлгийн шинэчлэл	2025	2,500.00	1,463.20	Зураг төсөвгүй
2	Төрийн үйлчилгээний Авто бааз байгуулах	2025	200.0	200.0	Зураг төсөвгүй, ашиглалтын тооцоо, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэрийн судалгаа байхгүй
3	Ёслол хүндэтгэлийн өргөөний засвар, шаардлагатай тоног төхөөрөмж	2025	200.0	200.0	Зураг төсөвгүй, ашиглалтын тооцоо судалгаа байхгүй
4	Ахмадын өргөөний барилга /Говь-Угтаал сум/	2025	150.	150.0	Зураг төсөвгүй, ашиглалтын тооцоо, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэрийн судалгаа байхгүй
5	Эко хог шатаах зуух /хог хаягдал, нүүрс шатааж дулаан гаргах/	2025	8,650.00	8,650.0	Зураг төсөвгүй, ашиглалтын тооцоо, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэрийн судалгаа байхгүй
6	Эрдмийн далай цогцолбор сургуулийн урлаг заал, гал тогооны хэсгийн пасадны засвар	2025	197.1	197.1	Төсөвтэй, зураггүй
7	Хөгжлийн төвийн шинэ барилга /Цагаандэлгэр/	2025	348.9	348.9	Зураг төсөв баталгаажуулаагүй
	Нийт дүн		12,246.0	11,209.2	

Орон нутгийн хөрөнгө оруулалтад 3,550.0 сая төгрөгийн 9 төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь тооцоо судалгаан дээр үндэслэгдээгүй, үр дүнд суурилж төлөвлөгдөөгүй байна.

2025 оны байгаль хамгаалах, нөхөн сэргээх, хөтөлбөр, арга хэмжээний жагсаалтад 2013 онд үйлдвэрлэгдсэн 230.0 мянган километрийн гүйлттэй автомашиныг худалдан авахаар тусгасан байна. Чанарын шаардлага хангаагүй хөрөнгө бэлтгэснээр ашиглалтын явцад техникийн эвдрэл бий болж төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах эрсдэлийг бий болгож байна. Цаашид ОНӨГ-аас орон нутгийн өмчит хуулийн этгээдээс дутагдалтай тээврийн хэрэгслийн судалгаа гаргуулан, хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, дүн шинжилгээ хийлгэж төсөвт тусгуулах шаардлагатай байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 29.4-т */хөрөнгө оруулалтын төсөвт техник эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл арга хэмжээг тусгана/*, Монгол улсын Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.2.2-т */төсөл арга хэмжээний саналд энэ журамд заасны дагуу судалгаа хийж, эрэмбэлэн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх нэн тэргүүний ач холбогдолтой төсөл арга хэмжээнүүдийг тодорхойлох, жагсаалт гаргах/*, мөн журмын 2.2.4-т */Төсөл, арга хэмжээний саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байх/* заасныг тус тус хэрэгжүүлээгүй, зөрчсөн байна.

2.3.3. Зураг төсөв, эдийн засгийн тооцоо судалгаагүйгээр төлөвлөсөн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг хуульд заасны дагуу төсөвлөлтийн шаардлагыг хангуулах шаардлагатай байна.

2.3.1. ТЕЗ-ийн ОНХС-ийн 2024 оны орлого бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн:

2024 онд аймгийн хэмжээнд ОНХС-гийн хөрөнгөөр 375 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр 22,471.7 сая төгрөгийг баталсан байна. 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн байдлаар 21,367.0 сая төгрөгийн эх үүсвэрээс 17,510.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Орлогын гүйцэтгэл 81.9 хувьтай, 18.1 хувиар тасарсан нь орон нутгийн өөрийн орлогын эх үүсвэрийн бүрдүүлэлтэй холбоотой байна. Тухайлбал: Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламжийн орлого 780.0 сая төгрөгөөр буюу 96.5 хувь, Малын тоо толгойн албан татварын орлого 617.9 сая төгрөгөөр буюу 56.4 хувиар тус тус тасарсан байна. Мөн 2023 оны гүйцэтгэлээр 955.9 сая төгрөг буюу 14.3 хувиар тасарсан, үүнээс тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламжийн орлого 573.2 сая төгрөгөөр буюу 55.4 хувь, малын тоо толгойн албан татварын орлого 439.5 сая төгрөгөөр буюу 27.1 хувиар тус тус тасарсан үзүүлэлттэй байна. Энэ нь тухайн онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээ удаашрах, цаашлаад хэрэгжихгүй он дамжих эрсдэлийг үүсгэж байна.

Төсвийн тухай хуульд орсон 2022 оны өөрчлөлтөөр тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нийгмийн хариуцлагын хүрээнд нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламжийн орлогыг тус санд төвлөрүүлж зарцуулахаар зохицуулагдсан бөгөөд 2023 онд аймаг болон Өндөршил сум, 2024 онд аймаг болон Адаацаг сумаас бусад сумд тус орлогыг төлөвлөөгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.⁹, 60.2.9.¹⁰ дахь заалттай нийцэхгүй байна. Орлогын төлөвлөлт бүрдүүлэлттэй холбоотой дээрх нөхцөл байдлаас харахад сангийн орлогыг хуульд заасан нэр төрөл тус бүрээр /ОНХНС-аас олгох орлогын шилжүүлгээс бусад/ тооцоолж төлөвлөх, биелэлтийг хангах, сангийн орлогыг нэмэгдүүлэх ажил хангалтгүй байна.

Иймд 2025 оны төсөвт аймаг, сумын ОНХС-д төвлөрүүлэх орлогыг хуульд заасан нэр, төрөл тус бүрээр тооцон төлөвлөж, орлогыг бүрэн төвлөрүүлэх, орлого бүрдүүлэлтэд хамаарах алба хаагч нарыг удирдлага арга зүйгээр хангаж, ажлын хариуцлагыг сайжруулж, сангийн орлогыг нэмэгдүүлэх асуудлаар үр дүнтэй ажил зохион байгуулж ажиллах шаардлагатай байна. Энэ асуудлаар 2024 онд ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар аймгийн Засаг даргад зөвлөмж хүргүүлсэн болно.

⁹ Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

¹⁰ Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан гэрээний дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламж.

"Орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх санал дүгнэлт гаргах"

Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний 2024 оны гүйцэтгэлийг аймаг, сумын дүнгээр авч үзэхэд 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн байдлаар 55.9 хувьтай буюу 210 хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Энэ нь малын тоо толгойн албан татварын орлогыг бүрэн төвлөрүүлээгүй, худалдан авах ажиллагааны зохион байгуулалт, зураг төсөв нь хийгдэж амжаагүй эсвэл зураг төсөвт өөрчлөлт оруулах шаардлагатай болсон, өөр санхүүгийн эх үүсвэрээр хийгдэхээр болсон, захиалагчаас хийгдэх шаардлагагүй гэж үзсэн зэргээс шалтгаалжээ.

2.3.2. Аймгийн ОНХС-ийн 2025 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын тухайд:

2025 онд аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 8,935.8 сая төгрөгийн 20 хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Үүнээс 2024 оноос шилжсэн 1,485.6 сая төгрөгийн 9, шинээр хэрэгжүүлэх 7,450.2 сая төгрөгийн 20 хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр төсөвлөсөн байна. 2025 онд хэрэгжүүлэх ажлын 3 нь барилга байгууламж, их засварын, 1 нь тоног төхөөрөмжийн, 7 нь хөтөлбөр арга хэмжээ буюу хөрөнгө оруулалтын зураг төсөв боловсруулах ангилалд хамаарах хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээ байна. Аймгийн ОНХС-ийн 2025 оны батлагдсан төсвийг өмнөх онтой харьцуулахад нийт 1,149.6 сая төгрөгөөр буюу 14.8 хувиар, ОНХС-аас олгох санхүүжилт 1,199.6 сая төгрөгөөр нэмэгдэж, орон нутгийн өөрийн орлогын эх үүсвэр 50.0 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Орон нутгийн өөрийн орлогын эх үүсвэр буурсан нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нийгмийн хариуцлагын хүрээнд нутгийн захиргааны байгууллагад өгөх хандив, тусламжийн орлогыг төлөвлөөгүйтэй холбоотой байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр санал болгож буй “Сайнцагаан сумын 6-р сургуулийн шинээр барих”, “Сайнцагаан сумын 9-р цэцэрлэг барих” ажлын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, урьдчилсан тооцоо судалгаа нь хийгдээгүй, хөрөнгийн ашиглалтын урсгал зардлыг тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлтийг гаргаагүй байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлын иргэдийн саналаар дэмжигдсэн байдлын хувьд урьдчилсан жагсаалтыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд танилцуулан санал авч нэгтгэсэн тухай нотлох баримтыг ирүүлсэн.

Харин сумдын төсвөөр бие даан хэрэгжүүлэх боломжгүй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг хүлээн авч ОНХС-ийн ажлын хэсгээр хянаж эрэмбэлсэн, эрэмбэлсэн саналыг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцсэн нэгдсэн жагсаалтыг бэлтгэсэн нотлох баримт ирүүлсэнгүй. 2025 онд шинээр хэрэгжүүлэх ажлууд иргэдийн саналаар дэмжигдсэн боловч эрэмбэлсэн дарааллаар нь жагсаалтад оруулаагүй байна.

Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны жилийн мөрийн хөтөлбөр боловсруулагдаж баталгаажуулагдах тул аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх

ажлуудын Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн нийцлийг шалгах боломжгүй байлаа.

Шинээр хэрэгжүүлэх ажлуудаас дараах арга хэмжээнүүд төлөвлөлтийн шаардлага хангахгүй байна.

- “Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайн гэрэлтүүлгийн шинэчлэл” /1,014.4 сая төгрөг/ ажлын техникийн нөхцөл, ажлын даалгавар, төсөв тооцоо судалгаа хийгдээгүй,
- “Сайнцагаан сумын 5,9-р байрны дээврийн засвар” /400.0 сая төгрөг/ ажлын төсөв нь 2021 онд боловсруулагдсан, жагсаалтад тусгагдсан дүнгээс зөрүүтэй, шинээр төсөв хийх шаардлагатай,
- Зураг төсөв боловсруулах /3,162.5 сая төгрөг/ 9 ажлын, тухайн ажил бүрийн хүрээнд хийж гүйцэтгүүлэх ажлын даалгавар, тэдгээрийн нэгжийн болон нийт өртгийг тооцсон судалгаа, зардлын тооцоолол, үндэслэл тодорхойгүй.

Хүснэгт 6: Төсөвлөлтийн шаардлага хангаагүй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ

Д/д	Хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Төсөвт өртөг /сая.төг/	Санхүү-жигдэх дүн /сая.төг/	Ангилал	Ажлын даалгавар, ТЭЗҮ, зураг төсөв боловсруулагдсан эсэх
1	Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайн гэрэлтүүлгийн шинэчлэл	2,500.0	1,014.4	Барилга байгууламж	Үгүй
3	Дээвэр засвар /5,9-р байр/	400.0	400.0	Барилга байгууламж	Үгүй
1	Сайнцагаан сумын 9-р цэцэрлэгийн зураг, төсөв боловсруулах	90.0	90.0	Төсөл, хөтөлбөр арга хэмжээ	Үгүй
2	Сайнцагаан сумын 5-р сургууль, 7-р цэцэрлэгийг авто замтай холбох ажлын зураг төсөв боловсруулах	20.0	20.0	Хөтөлбөр арга хэмжээ	Үгүй
3	Сумын төвийн нэгдсэн халаалт, цэвэр ус, ариутгах татуургын ажлын зураг төсөв боловсруулах /Өндөршил сум/	300.0	300.0	Төсөл, хөтөлбөр арга хэмжээ	Үгүй
4	Сумын төвийн нэгдсэн халаалт, цэвэр ус, ариутгах татуургын ажлын зураг төсөв боловсруулах /Баянжаргалан сум/	300.0	300.0	Төсөл, хөтөлбөр арга хэмжээ	Үгүй
5	Сайнцагаан сумын 6-р сургуулийн зураг, төсөв боловсруулах	121.0	121.0	Төсөл, хөтөлбөр арга хэмжээ	Үгүй
6	Аймгийн төвийн 3.9 км авто зам шинээр барих ажлын зураг төсөв боловсруулах	300.0	300.0	Төсөл, хөтөлбөр арга хэмжээ	Үгүй
7	Зураг төсөв, ТЭЗҮ боловсруулах	2,031.5	2,031.5	Төсөл, хөтөлбөр арга хэмжээ	Үгүй
Нийт дүн		6,062.5	4,576.8		

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29.4¹¹, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг

¹¹ Хөрөнгө оруулалтын төсөвт техник эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл арга хэмжээг тусгана

төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам” – ын 3.1.4.4¹², Сангийн сайдын 2021 оны 86 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3 дугаар зүйлийн 4.1.3¹³ дахь заалтад заасан шаардлагад нийцэхгүй байна.

Баталгаажсан зураг төсөв, тооцоо судалгаагүй хөрөнгө оруулалтыг төлөвлөсөн нь хууль тогтоомж зөрчих, төлөвлөсөн ажил хугацаандаа хэрэгжихгүй байх, улмаар өөр хэрэгцээ шаардлагатай, ач холбогдолтой хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэх боломжийг хааж сангийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулж, орон нутагт үр ашиггүй хөрөнгө нэмэгдэх үр дагавартай байна.

¹² 3.1.4. “ТЭЗ нь ... төсөл, арга хэмжээний саналыг ирүүлэхдээ дараах шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг судалж, холбогдох тайлан болон баримт бичгийг хавсаргасан байна: ... 3.1.4.4. төслийн зардлыг бүрэн зөв тооцсон эсэх”

¹³ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр арга хэмжээ нь хууль заасны дагуу зураг төсөв, техникийн эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх.

"Орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх санал дүгнэлт гаргах"



Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Дундговь аймгийн 2025 оны суурь орлогыг 32,827.2 сая төгрөгөөр тогтоож, УИХ-аас нийт орлогыг 33,053.2 сая төгрөгөөр баталсныг ТЕЗ-аас 9,505.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж 42,558.9 сая төгрөг байхаар санал гаргасан байна.
2. Аймгийн төсвөөс АХБ-ны МОН 2301 төсөл /Гурвансайхан сумын дэд бүтэц/ зээл, АХБ-ны МОН 3713 төсөл /Сайнцагаан, Эрдэнэдалай сумын цэвэрлэх байгууламж/ зээлийн нийт 1,630.9 сая төгрөгийг 2025 онд төлөхөөр төсвийн зардалд тусгасан боловч эх үүсвэр дээр хүүгийн орлого /дамжуулан зээлдүүлэхийн/ 566.9 сая төгрөгийн эх үүсвэр тодорхойгүй, бодит бус орлого төлөвлөсөн байна.
3. Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн дагуу төсөвт 1.4 тэрбум төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэх боломжтой байна.
4. Түгээмэл тархацтай ашигт малтмалаас орох орлогыг хуульд заасан нөхцөл, журмын дагуу ашиглах нөхцөл бүрдээгүй байхад төлөвлөж байгаа нь төлөвлөгөөт орлого тасрах эрсдэлийг бий болгож байна.
5. Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй ч үйл ажиллагаа явуулахгүй байгаа аж ахуй нэгжүүдийг гэрчилгээжүүлэх замаар газрын төлбөрийн орлогыг өмнөх оноос 2.5 дахин нэмэгдүүлэхээр төлөвлөсөн ч аж ахуй нэгжүүд гэрчилгээ авч төлбөр төлөх эсэх нь тодорхойгүй, газрын төлбөрийн орлогын төлөвлөгөө тасрах эрсдэлтэй байна.
6. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг төлөх арга хэрэгслийг оновчтой сонгож, хог хаягдлын хураамжийн хэмжээг нормативт үндэслэн шинэчлэн тогтоосноор орлогын хэмжээг нэмэгдүүлэх боломжтой.
7. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийг 2025 онд хөгжүүлэх жилийн төлөвлөгөө батлагдаагүйгээс аймгийн 2025 оны төсвийн төсөл нь түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн эсэхийг дүгнэх боломжгүй байна.
8. Орон нутгийн төсвийн зардлыг төлөвлөхдөө арга хэмжээний хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг тодорхойлохгүй, төсвийн задаргаа байхгүй, тооцоо судалгаа хийгээгүй зэрэг нийтлэг алдаа дутагдал байгаа нь зардлыг бодитой бус төлөвлөх эрсдэлийг бий болгож байна.
9. Зураг төсөв, эдийн засгийн тооцоо судалгаагүйгээр төлөвлөсөн ОНХС-ийн төсвөөр хэрэгжүүлэх ажлуудыг хуульд заасны дагуу төсөвлөлтийн шаардлагыг хангуулан, иргэд, олон нийтийн оролцоог хангах ажлын чанарыг сайжруулж, хандив тусламжийн орлогыг төсөвт тусгах шаардлагатай байна.
10. Баталгаажсан зураг төсөв, тооцоо судалгаагүй хөрөнгө оруулалтыг төлөвлөсөн нь хууль тогтоомж зөрчих, төлөвлөсөн ажил хугацаандаа хэрэгжихгүй байх, улмаар өөр хэрэгцээ шаардлагатай, ач холбогдолтой хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэх

боломжийг хааж сангийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулж, орон нутагт үр ашиггүй хөрөнгө нэмэгдэх үр дагавартай байна.



Зөвлөмж

Аудитын нотлох баримт, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн Засаг даргад:

1. Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл арга, хэмжээг техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвийг батлуулж, судалгаа шинжилгээ хийж, эрэмбэлэн, нэн тэргүүний ач холбогдлыг тодорхойлж, жагсаалт гарган, үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэрийг тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын дүгнэлтийг гаргаж орон нутгийн төсөвт тусгуулах;
2. Сумдад малын тоо толгойн албан татварын хэмжээг бэлчээрийн даацтай уялдуулан тогтоож, орлогыг төлөвлөн, Төсвийн тухай хуулийн 60.2.8-д заасны дагуу зарцуулж байх талаар чиглэл хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;
3. Орон нутгийн төсвөөс төлөх 1,630.9 сая төгрөгийн зээлийн төлбөрийн эх үүсвэрийг аймгийн 2025 оны төсөвт бодитоор төлөвлөх;
4. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг олон нийтийн оролцоотой төлөвлөх ажлыг хууль, журам, зааврын дагуу чанартай зохион байгуулж, өндөр санал авч эрэмбэлэгдсэн дарааллаар хөрөнгө оруулалтыг жагсаалтад тусгаж санхүүжүүлж байх;
5. Төлөвлөлтийн шаардлага хангаагүй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний зураг төсвийг хийлгэж, зураг төсөв боловсруулах ажлын, тухайн ажил бүрийн хүрээнд хийж гүйцэтгүүлэх ажлын даалгавар, тэдгээрийн нэгжийн болон нийт өртгийг тооцсон судалгаа, зардлын тооцоолол, үндэслэлийг тодорхой болгож хууль тогтоомжид нийцүүлэх;
6. Хог хаягдлын хураамжийн хэмжээг тогтоохдоо Сангийн сайд болон БОАЖС-ын 2018 оны 192, А/243 дугаартай “Аргачлал батлах тухай” аргачлалыг үндэслэн энгийн хог хаягдлыг цуглуулж тээвэрлэх зардлын тарифыг тооцож, түүнд үндэслэн хог хаягдлын хураамжийн хэмжээг тогтоон, хураамжийг цахилгааны төлбөртэй хамтатган авах;
7. Эрх бүхий албан тушаалтнууд бүрэн эрхийн хүрээнд түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд заасан шаардлагын дагуу ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллага бий болгох нөхцөл боломжоор хангах, түүнд тулгуурлан орлогыг үндэслэлтэй төлөвлөх;

8. “Ид шидийн орон”-ны зардал, “Эрдмийн далай хүүхэд хөгжлийн төв”-ийн үйл ажиллагааны алдагдлыг татаас хэлбэрээр олгохгүй, төрөөс гүйцэтгүүлэх чиг үүргийг тодорхойлж гэрээ байгуулан хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг тодорхой болгож, хэрэгжилтийг тооцон ажиллах.

2023 оны малын тоо, толгой, 2025 оноос мөрдөгдөх татварын хэмжээ

№	Сумд	Бэлчээрийн даац багтаамж, хонин толгой	Ачаалал, хонин толгой	Бэлчээр ашиглалт, хувь	Даац хэтэрсэн /дахин/	2025 онд хэрэгжих тогтоолоор батлагдсан татварын хэмжээ сумдаар						
						Огноо	Дугаар	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
1	Адаацаг	208,092	631,179	303.3	3.0	12/18/2020	13	1000	1000	1000	300	400
2	Баянжаргалан	114,130	273,138	239.3	2.4	12/7/2020	3	1000	1000	1000	500	500
3	Говь-Угтаал	129,656	379,846	293.0	2.9	12/18/2020	12	2000	2000	2000	400	500
4	Гурвансайхан	220,061	521,615	237.0	2.4	6/24/2022	44	1000	1000	1000	400	500
5	Дэлгэрхангай	274,827	406,015	147.7	1.5	12/18/2020	12	1000	1000	1000	500	500
6	Дэлгэрцогт	138,500	392,613	283.5	2.8	5/7/2021	11	1000	1000	0	400	500
7	Дэрэн	178,100	559,986	314.4	3.1	12/18/2020	11	1000	1000	0	400	500
8	Луус	137,723	407,379	295.8	3.0	1/26/2021	15	1500	500	0	300	600
9	Өлзийт	395,558	680,510	172.0	1.7	10/11/2021	22	2000	2000	0	400	500
10	Өндөршил	143,319	362,184	252.7	2.5	12/17/2021	33	500	500	0	500	500
11	Сайнцагаан	196,353	796,984	405.9	4.1	4/24/2024	12	750	0	0	200	250
12	Сайхан-Овоо	176,150	415,964	236.1	2.4	12/16/2021	25	1000	1000	1000	200	250
13	Хулд	187,951	574,382	305.6	3.1	12/10/2021	06./01	500	500	500	200	400
14	Цагаандэлгэр	153,424	296,947	193.5	1.9	12/19/2020	12	1000	1000	1000	400	500
15	Эрдэнэдалай	330,411	1,098,613	332.5	3.3	12/29/2020	18	1000	1000	0	400	500
Аймгийн хэмжээнд		2,984,255	7,797,352	267.5	2.7							